

"МОННАБ" ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН /Хураангуй/

Үзүүлэлтүүд	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
<b>Баланс</b>		
Мөнгөн хөрөнгө	20,018.47	20,018.47
Дансны авлага	72,796,033.07	72,796,033.07
Татвар,НДШ-ийн авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал		-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	24,890,981.61	24,890,981.61
Бусад эргэлтийн хөрөнгө		-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		-
Үндсэн хөрөнгө	19,784,987.70	19,784,987.70
Биет бус хөрөнгө		-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>117,492,020.85</b>	<b>117,492,020.85</b>
Дансны өглөг	102,621,781.04	102,621,781.04
Цалингийн өглөг		-
Татварын өглөг		-
НДШ-ийн өглөг		-
Бусад богино хугацаат өр төлбөр		-
Хүүний өглөг		-
Урьдчилж орсон орлого		-
Урт хугацаат зээл		-
Эздийн өмч-хувийн	12,276,700.00	12,276,700.00
Нэмж төлөгдсөн капитал		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	95,895,164.00	95,895,164.00
Эздийн өмчийн бусад хэсэг		-
Хуримтлагдсан ашиг	(93,301,624.19)	(93,301,624.19)
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>	<b>117,492,020.85</b>	<b>117,492,020.85</b>
<b>Орлого үр дүнгийн тайлан</b>		
Борлуулалтын орлого (шэвэр)		
Борлуулсан өртөг		
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	-	-
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого		
Ногдол ашгийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	2,930,900.00	2,930,900.00
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
Бусад ашиг (алдагдал)		-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(2,930,900.00)</b>	<b>(2,930,900.00)</b>
Орлогын татварын зардал		
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(2,930,900.00)</b>	<b>(2,930,900.00)</b>
<b>Өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
2015 оны 01 сарын 01-ны үлдэгдэл	17,801,139.81	17,801,139.81
Нэмэгдсэн өөрчлөлт		
Хасагдсан өөрчлөлт	(2,930,900.00)	(2,930,900.00)
2015 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	14,870,239.81	14,870,239.81
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(3,009,400.00)	(3,009,400.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
<b>Бүх шэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,009,400.00)</b>	<b>(3,009,400.00)</b>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,029,418.47	3,029,418.47
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,018.47	20,018.47

Ажлын тэмдэглэл: Барилга угсралтын үйл ажиллагаа явуулагд.

Зөвлөмж: Улсын Бүртгэлийн гэрчилгээ дээр дүрмийн сан 109 426 800 төгрөг, Баланс дээрх дүрмийн сан зөрүүтэй байгааг анхаарч холбогдох өөрчлөлтийг хийх талаар зөвлөлтөг өгөв.

Аудитор:  Д.Алтантөгс/  
Аудиторын туслах: ..... /Э.Цэнгэл/

**“МОН-НАБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 дүгээр  
сарын 31-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн саналыг  
тоолсон дүнгийн тухай**

Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж үзэхэд нийт тараагдсан саналын хуудас 5 ширхэг, санал авагдаад буцаж ирсэн 5 ширхэг хуудсанд 100912 ширхэг хувьцааны санал ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 82 % болж, үүнээс хүчинтэй 5 ширхэг саналын хуудас, хүчингүйд тооцсон 0 ширхэг саналын хуудас байна. Эдгээр саналыг хэлэлцсэн асуудал бүрээр тодорхойлбол:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны, санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлтийг зөвшөөрсөн 100912 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй
2. ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлахыг зөвшөөрсөн 100912 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй
3. Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлахыг зөвшөөрсөн 100912 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолоход

- Т. Бадамжунай 62400 санал
- Р.Зоригт 37497 санал
- Би Ди Сек ХК 3 санал
- М.Энхтайван 837 санал
- Р.Хандсүрэн 175 санал тус тус тоологдож хэлэлцсэн асуудлыг 100 % санал нэгтэй баталлаа.

Тооллогын комиссын дарга  
комиссын гишүүн



Л.Амарсайхан  
Г.Төгөлдөр

**“МОН-НАБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“МОН-НАБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 03 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотноо, компанийн байранд болов. Хурал 14.00 цагаас эхлэж, Гүйцэтгэх захирал Ш.Оюун-Эрдэнэ даргалан явуулав.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигч:

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Би Ди Сек ХК / 3 ширхэг хувьцаа эзэмшигч/
- М.Энхтайван / 837 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Р.Хандсүрэн / 175 ширхэг хувьцаа эзэмшигч/

нар тус тус хүрэлцэн ирж, ирц 82.0 хувьтай байв.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

- Компанийн 2015 оны үйл ажиллагааны санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилгыг хэлэлцэж батлах

Хувьцаа эзэмшигчдийн хуралд “Компанийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлт”-ийг ТУЗ-ийн дарга Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

Хувьцаа эзэмшигчид 2015 онд МОННАБ ХК нь албан ёсны цахим хуудас болох MONNAB .mn хаягтайгаар нээж ажиллууллаа. Энэ хуудсаар дамжуулан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл тавигдаж байгаа. 2015 онд хурлаа хийгээд өртэй байсан Мандал хүрээ компанийн нэхэмжлэлтэй 6,0 сая төгрөг Нийгмийн даатгалын 9,0 саяаас хагаслан төлж, Татварын хяналт шалгалтын 63,0 сая төгрөгийн өрийг шүүхээр шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх хурлаар орж хүчингүй болсон боловч Нийслэлийн татварын газраас давж заалдахаар шүүхэд хандаад байгаа. Нийслэлийн татварт энэ асуудлаа Ершөөлийн хуулийн заалтад хамруулахаар тайлбар өгсөн хариу ирээгүй байна. Энэ шүүх хуралд компанийг төлөөлж оролцуулахаар Аудитын байгууллагатай гэрээ хийж татварын итгэмжлэгдсэн төлөөлөгч авч ажиллуулсан. Ямар ч байсан эдгээр өр төлбөрөө яаж ямар арга замаар төлж барагдуулж дуусгах талаар та нар санал хэлэх байх. Зарим нэг өрүүдийг шийдвэрлүүлээд, зарим нэгийг нь хасуулав. Холбогдох тооцоо баланс нь байгаа. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хүрээнд өөрийн байгууллагын санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудын өгсөн. Энэ зун дулааны шугамд засвар хийх шаардлагатай болсон дулаанаа авдаг ерөнхий шугамаас ойр хэвийн байгууллагуудын дундын шугам өнгөрөгч намар хагарч дулаан доголдон арай гэж аргалж төлгөөрсөн энэ засварт 370000 төгрөг төлсөн одоо энэ шугамын засварыг хийхгүй бол ирэх намар дулаан авахад хүнд

болно. Мөн конторын барилга, гражийн барилгын ханаар дулаан алдаад байна хөөсөн хавтангаар дулаалах шаардлагатай, дээврийн засварын ажлуудыг хийнэ. Холбогдох тооцоо баланс нь байгаа. Жилийн урсгал зардлууд ерөнхийдөө төлөгдөж яваа үүнд: газрын төлбөр, дулаан цахилгааны төлбөр, утас, вэб хуудасны төлбөр, Хөрөнгийн биржийн хураамж өнгөрсөн жилийн хийсэн ажлууд ийм байна гэв. Энэ жил СЗХорооноос хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар хийлгэх мэдэгдэл ирсэн үүний дагуу компанийн аудитын хорооны судалж санал болгосон аудитын компанитай гэрээ хийж дүгнэлт гаргуулсан.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв.

**М.Энхтайвэн:** Би олон жилийн дараа ирж хуралд оролцож байна. Би энд ажиллаж байсан үеийн тушаал авахаар ирсэн Оюун-Эрдэнэ хурдан шуурхай олж өгсөн гэтэл Сувраган компанийн тушаал байхгүй байна. Үүнийг хэнээс хэачаас олох вэ?

**Ш.Оюун-Эрдэнэ:** Надад та нарт хэлэх зүйл байна. Би энэ ажлыг хийж чадахгүй гэж хэлмээр байна. Яагаад гэвэл би цалингүй маш их ажиллаа одоо надад цалин шийдэж өгөхгүй бол би дандаа ийм байдлаар байна гэдэг хэцүү байна шүү дарга нараа. ТУЗ-н хувьд сайн ажиллаа гэж би үзэж байна. Яагаад гэвэл өнгөрч байгаа онуудад маш их хэмжээний ерийг барьдгуулах ажлыг Зоригт ТУЗ-н даргын хувьд ч хувьцаа эзэмшигчийн хувьд ч идэвхи гарган янз бүрийн байдлаар төллөө. Энэ хүн чинь бас амьдралтай хүн шүү дээ гэдгийг мартаж болохгүй.

**Р.Зоригт:** Ш.Оюун-Эрдэнийг одоогоор ажиллуулж байхгүй бол өөр хүн алга. Харин цалин шийдэж өгөх нь зөв байх. Ажил хийж болно. Тусгай зөвшөөрөл өгөхгүй байна. Бас татварын шалгалтаар маш их хэмжээний торгууль тавигдсан байгаа. Бид анхан шатны шүүхээр ялсан боловч татвараас даваж заалдаад ахин шүүхээр орох гэж байна.

**Ш.Оюун-Эрдэнэ:** Энхтайваны асуултанд би хариулья энд байгаа тушаал цалингийн хүснэгтүүдээс өнгөрсөн жил 7-8 хүн ирж хуулбар авсан. Олон хүнд архиваас лавлагаа олгосон бүгд баяртай явсан. Харин Сувраган, Чандмана компанийн тушаалууд байхгүй учир ажилд орсон гарсан тушаал өгөх боломжгүй байсан. Бид байгаа тушаалуудыг архивт өгөх хэрэгтэй байна.

**БиДиСек:** Төлөөлж ирсэн Мэргэжилтэн Б.Билгүүн цаашид ямар ажил төлөвлөж байна вэ? Инженер, техникийн ажилтнууд байна уу? Компанийн энэ жилийн зорилт юу байна.

**Р.Зоригт:** Цаашид компанийг зориулалтын нь дагуу ажиллуулна. Энэ бол миний, та нарын хөрөнгө, Манай хуучин ажилчид ихэнх нь тэтгэвэрт гарсан зарим нь өөр ажил хийж байгаа иймээс шинээр ИТА, ажилчид авч таарах байх. Би олон ажил хийж байгаа. Тэр хүмүүсээ мөн ажиллуулна. Одоогийн инженер техникийн ажилтнууд цалин өндөртэйгээр бусад газруудад ажиллаж байна. Мөн инженерүүд заавал зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай байгаа.

Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь хэдгараад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийг ажил хийнэ гэдэг хэцүү. Өөр ажил хийхээр хувьцаа нэмж гаргах шаардлагатай болно. Энэ нь их асуудалтай нилээд ажил байдаг. Хөрөнгө оруулалтын ажлаа ийшээ чиглүүлнэ гэсэн бодолтой.

Ш.Оюун-Эрдэнэ: Энд байгаа улсууд хийх юмаа хийж л байгаа байх өрөө дарахгүй бол хэцүү ажил хийх ажилчид боловсон хүчнээ сайн сонгож авах хэрэгтэй.

Р.Зоригт: Төслийн ажил хийсэн нь арай дээр гэж бодож байна.

Р.Хандсүрэн: Би анх удаа хуралд ирж оролцож байна. Би нөхрийнхөө ажилд орсон гарсан тушаал авахаар ирэхэд энэ хүн түргэн шуухай гаргаж өгсөн баярлалаа. Энэ компани ноогдон ашиг тараах уу.

Ш.Оюун-Эрдэнэ: Би хувьцаагаа зармаар байна. Ноогдон ашиг өгөхгүй юмуу гэсэн хүмүүс л их байдаг. Энэ байгууллагын ажил төрөл ямар байдлаар яаж ашигтай ажиллуулбал зүгээр талаар оновчтой санал хэлэх хүн байна уу. Бид өөрсдөө гар бие оролцохгүй байж хүн шүүмжлээд яах вэ.

Р.Зоригт: Ноогдон ашиг тараана гэдэг ашигтай ажиллаж байж хийх ажил. Манайх үйл ажиллагаа байхгүй байгаа тул ноогдон ашиг тараах боломжгүй. Та нар надтай уулзаарай.

Ш.Оюун-Эрдэнэ: Зоригт Бадамжунай даргатай юу ярьж байнаа. Тэр хүн одоо юу хийж байна.

Р.Зоригт: Би Бадамжунай даргатай уулзсан бидэнд туслана гэсэн.

Ш.Оюун-Эрдэнэ: СЗУ-ооо, ХБиржээс маш олон мэдэгдэх хуудас шаардлагууд ирсэн. Тэр болгонд харну өгөх шаардлагатай болдог. Манай компани MONNAB.MN гэсэн вэб сайттай болсон. Үйл ажиллагааг өөр чиглэлээр явуулах гэсэн айлд байхгүй юу?

Р.Зоригт: Ер нь түрээслээгч, зараач гэсэн саналууд их ирдэг.

БиДиСек: ТУЗ-ийн хурал дээр ажил муу байсан гэдгийг сануулах хэрэгтэй. Ямар менежментээр яаж ажиллах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй. Хөрөнгө оруулалт их болж байна. Энэ бол бидний хөрөнгө. ТУЗ хуралдах хэрэгтэй байна.

Р.Зоригт: Надад бодож байгаа бодол байна. Болох байлгүй дээ. Ер нь Бадамжунай, Пүрэвдорж нартай уулзаж чаарвал ирэнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн цаацдын зорилтыг хэлэлцэв.

Компанийн цаацдын зорилтыг хэлэлцэн батлахтай холбогдуулан Р.Зоригт өөрийн саналаа хэлэв. - 2016 онд өр төлбөрөө төлж дуусгах бодолтой байна.

- Тэтварын шалгалгаар тааигдсан өрийг шийдвэрлүүлэх

- Дулааны шугамын урсгал засварыг журдан чанартай хийж дуусгах

- Гражийн дээврийн засвар, конторын бариллыг гаднаас нь дулаалга хийх

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дээрхи саналыг санал нэгтгэй батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг хэлэлцэж, тэдгээрийг санал нэгтгэйгээр батлав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 17.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХЕТЭЛСЭН



Ш.Оюун-Эрдэнэ  
Г.Төгсүлдэр